



**ОКСФОРДЫН ИХ СУРГУУЛЬ
ГАЗАРЗҮЙ, БАЙГАЛЬ ОРЧНЫ СУРГУУЛЬ**

**МОНГОЛ УЛСЫН
УУЛ УУРХАЙН САЛБАР ДАХЬ НИЙГМИЙН
НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ СУРГАЛТ**

**2020 ОНЫ
6-Р САРЫН 8, 9-НИЙ ӨДӨР**

**ОКСФОРДЫН ИХ СУРГУУЛИЙН
СЕРТИФИКАТ
ОЛГОХ СУРГАЛТ**

✓ ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Сүүлийн хэдэн арван жилд Монгол Улс томоохон өөрчлөлтүүдтэй тулгарч, хөдөө орон нутагт ашигт малтмал олборлох үйлдвэрлэлд төрийн болон гадаадын хөрөнгө оруулалт эрс нэмэгджээ. Ашигт малмалын олборлолт орон нутагт нэмэгдэхийн зэрэгцээ малчдын бэлчээр нутгийг хамрах болсон байна. Монголд ДНБ-ий 27% -ийг бүрдүүлж буй 1840 гаруй уул уурхайн компаниуд экспортын 80 гаруй хувийг бүрдүүлж, ажиллах хүчний 4% -ийг ажлын байраар хангаж байна.

Энэ бүс нутагт ОУСК, ЕСБХБ зэрэг олон улсын хөрөнгө оруулагчдаас санхүүжүүлдэг мега уурхайнууд олон улсын хөдөлмөр, байгаль орчин, нийгмийн хариуцлагын стандартыг сайн дураараа дагаж мөрддөг. Олон улсын томоохон банкуудаас санхүүжилт, зээл авдаггүй компаниуд хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл авах, олборлолт эхлүүлэхдээ зөвхөн Монгол улсын хууль журмыг дагаж мөрддөг. Монгол Улс хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх асуудлыг байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, аргачлалд тусгасан боловч нийгмийн хамгаалалын талаар ижил төстэй аргачлал хараахан боловсруулаагүй байна. Монгол Улсын Засгийн газраас тус салбарт хариуцлагатай уул уурхай хөгжүүлэхийн тулд өөрийн аргачлал, стандарт боловсруулах ажлыг хийж байна. Монголд боловсруулж буй бодлого, аргачлал нь Төв Азийн орнууд, тухайлбал Киргизстан зэрэг улсад тэргүүлэх туршлага болж болох юм.

✓ СЕМИНАРЫН ЗОРИЛГО

Өнгөрсөн жилүүдэд өргөжин тэлэх болсон том, дунд уул уурхай, жижиг бичил уурхай Монгол Улсын улс төр, эдийн засаг, газар ашиглалт, амьжиргааны асуудал, ажил эрхлэлт зэргийг ихээхэн хувирган өөрчилсөн билээ. Тус сургалт нь Оксфордын Их сургуулийн Нийгмийн нөлөөллийн үнэлгээний талаар сертификат олгох сургалтын нэг хэсэг бөгөөд тус семинар дээр дараах хэдэн асуудал төвлөрч байна. Үүнд:

- Уул уурхайн нийгмийн нөлөөлөлтэй холбоотой шилдэг туршлага, сүүлийн үеийн чиг хандлагын талаар мэдлэг туршлага хуваалцах;
- Монгол улсад явуулсан хээрийн шинжилгээний ажлын үр дүнд уул уурхайн нийгмийн нөлөөллийн талаар баримт мэдээлэл хуваалцах;
- Их Британийн экспертүүд болон Монголын бодлого тодорхойлогч нарын хооронд тогтвортой түншлэл бий болгох.

✓ ИНТЕРНЭТ ЗУУМ АППЛИКЕЙШН АШИГЛАХ

Энэ сургалт семинарыг Зүүм (Zoom) интернэт хурлын платформ ашиглаж явуулах юм. Монгол Улсын оролцогчид Улаанбаатар хотын Блю Скай зочид буудлын Кристал өрөө хурлын зааланд цуглаж сургалтанд оролцох бөгөөд хэлэлцүүлэг хийж харилцан ярилцах юм. Уг хурлын заалыг Н. Баярсайхан зохицуулах болно.

Их Британи дахь оролцогчид Зүүм хурлын аппликейшнийг компьютер дээрээ татан суулгаж өөрийн хаяг нэрээр орсон байх шаардлагатай. Компьютер камер болон микрофонтой байх ёстой.

ХӨТӨЛБӨР

2020 ОНЫ 6-Р САРЫН 8

12:30 — Үдийн хоол

14:00 — Зохион байгуулагчид болох Ариель Айхерн нарын нээлтийн үг

14:20 — Оксфордын Их Сургуулийн Олон улсын стратеги хариуцсан ахлах мэргэжилтэн Крейг Морлигийн нээлтийн үг

14:40 — Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Салбарын удирдлага, зохицуулалтын газрын дарга Шаравын Мөнхцэрэнгийн нээлтийн үг

15:00 — Нийгмийн нөлөөлөл ба нүүлгэн шилжүүлэлт
Доктор Жилл Шанклеман

15:30 — Асуулт хариулт

15:45 — Кофе, цайны завсарлага

16:00 — Байгаль орчны хууль
Оксфордын Их сургуулийн Хуулийн сургуулийн профессор Лиз Фишер

16:45 — Асуулт хариулт

17:00 — Нүүдэлчин Хүмүүсийг Нүүлгэн Шилжүүлэх Боломжтой юу?
Оксфордын Их сургуулийн Олон Улсын Хөгжил, Дүрвэгсдийн Судалгааны Төвийн Профессор Доун Чатти

17:45 — Асуулт хариулт

18:00 — Хүндэтгэлийн зоог, хэлэлцүүлэг

2020 ОНЫ 6-Р САРЫН 9

12:30 — Өдрийн хоол

14:00 — Оксфордын Их Сургуулийн судалгааны кейс танилцуулга

- Гурвантэс, Ханбогд сум, Сүхбаатар аймагт явуулсан судалгаанд гарч буй нийгмийн нөлөөллийн талаарх тойм, Говийн загвар судалгааны баг
- 2019 оны 12-р сарын 3-ны өдөр зохион байгуулсан 41 дүгээр зүйлийн хэрэгжилтийн талаар хийсэн Зөвлөлдөх уулзалтын тайлан, Н.Баярсайхан

14:45 — Асуулт хариулт

15:00 — Нийгмийн нөлөөллийн үнэлгээний аргачлал боловсруулж буй явц,
Санчир Жаргалсайхан

15:30 — Асуулт хариулт

15:45 — Кофены завсарлага

16:00 — Уул уурхайн салбарт зориулсан агаарын тандан судалгааны аппликешн

- Катапулт болон программын талаар танилцуулга, Олборлох үйлдвэрлэлийн хэлтсийн дарга Алистэйр Лийс
- Агаараас тандан судлах аппликешны талаарх танилцуулга, Газрыг агаараас тандан ажиглах ахлах мэргэжилтэн Др. Кристиан Росси
- Агаараас тандан судалгааны аппликешн ашиглаж Монголын уул уурхайн салбарыг судалсан жишээ, Газрыг агаараас тандан ажиглах мэргэжилтэн Баяраагийн Марал

16:45 — Асуулт хариулт

17:15 — Нийгмийн нөлөөллийн үнэлгээ ба үр өгөөжийг хуваалцах
Доктор Эмма Вилсон

18:00 — Хүндэтгэлийн зоог, хэлэлцүүлэг

ИЛТГЭГЧДИЙН ТОВЧ НАМТАР



АРИЭЛЛ ЭХАРН

Оксфордын Их сургуулийн Байгаль, нийгэм, хүрээлэн буй орчны засаглалын Магистрын (MPhil) хөтөлбөрийн захирал, Оксфордын их сургуулийн Газарзүй, байгаль орчны сургуулийн багш. 2004 оноос хойш тэрээр Монгол орны хөдөө нутагт газар ашиглалт, хөдөөгийн хөгжлийн асуудлаар бэлчээрийн мал аж ахуй эрхлэгч нутгийн малчидтай ажиллаж байна. Хөдөөгийн нийгмийн өөрчлөлт, өнөөгийн бэлчээрийн мал аж ахуй эрхлэгчдийн газар ашиглалт, орон нутгийн засаглалын талаар Докторын судалгаа явуулсан. Тэрээр 2016 онд Олон улсын санхүүгийн корпорацийн Омбудсманы газрын гомдол барагдуулах ажлын хүрээнд Оюу толгой мега уурхайтай холбоотой нийгэм-эдийн засгийн өөрчлөлт, малчдын амьжиргааны талаар чанарын судалгаа хийх салбар дундын хөндлөнгийн судалгааны багийн экспертээр ажилласан. Монголын хөдөөгийн хөгжил тухайлбал өрх хуваагдах, боловсрол, хүйс, орон нутгийн газар бэлчээр нутгийн зохицуулалт зэрэг олон сэдвээр судалгааны бүтээл туурвиж хэвлүүлсэн байна. Ариел ESRC-GCRF-ийн санхүүжилтээр хэрэгжиж буй Говийн загвар: Тогтвортой дэд бүтцийн хөгжлийн зуучлалын загвар төслийн дэд захиралаар ажиллаж байна.



АЛАСТЕЙР ЛИС

Хиймэл дагуулын Аппликешн Катапулт компаниудын холбооны Глобал үйлчилгээ хөгжүүлэлтийн дарга байсан бөгөөд одоо тус компанийн Олборлох үйлдвэрлэлийн хэлтсийн дарга Тэрээр Accenture-д эхэлсэнээс хойш дэлхийн тэргүүлэх бизнес, мэдээллийн технологийн төслүүдэд 20 гаруй жил ажилласан туршлагатай. Аластейр нь Бразилд гарааны бизнесийг бусадтай хамтран амжилттай эхлүүлсэн бөгөөд, португаль хэлээр чөлөөтэй ярьдаг. Хамгийн сүүлд Аластейр нь Cloudreach компанийн төслийн удирдагчаар ажиллаж, үүлэн технологи хөгжүүлэлтийн гарааны бизнесийг дэлхийн хорь гаруй байршилд нэвтрүүлсэн. Alastair нь шинэлэг технологийг үр дүнтэй ашиглах замаар байгууллагын үйл ажиллагааг сайжруулах хүсэл эрмэлзэлтэй. Аластейр Йоркийн Их сургуулийн Мэдээллийн технологи, бизнесийн удирдлага, хэлний чиглэлээр бакалавр зэрэгтэй.



ДЖИЛЛ ШАНКЛЕМАН

Дэлхийн Банкны улс төрийн эрсдлийн даатгалын асуудлыг эрхлэх байгууллага болох Олон талт хөрөнгө оруулалтын баталгааны агентлаг (MIGA) болон Недаерландын Хоёр талт хөгжлийн банкны (FMO) нийгэм, байгаль орчны асуудал хариуцсан ахлах мэргэжилтэнээр 25 жил ажиллаж байна. Тэрээр газрын тос, байгалийн хий, уул уурхай, эрчим хүч, био түлш, дэд бүтцийн төслүүдийн чиглэлээр ажилладаг. Байгалийн баялаг ихтэй улс орнуудад газрын тосны үйлдвэрлэл, сайн дурын стандарт, зөрчлийн дараах тогтворжуулалтын талаар олон бүтээл туурвисан. Азербайжан, Боливи, Казахстан, Монгол, Нигери, Орос, Сьерра-Леоне, Өмнөд Судан, Турк, АНУ, Их Британи зэрэг дэлхий олон орнуудад ажиллаж байв.

ОКСФОРДЫН ИХ СУРГУУЛЬ



МАРАЛ БАЯРАА

Хиймэл дагуулын аппликешны Катапулт байгууллагын хиймэл дагуулын газрын тандан судалгааны мэргэжилтэн бөгөөд уул уурхайн мөчлөг тухайлбал ашигт малтмалын хайгуул, хаягдлын далангийн мониторинг, байгаль орчны үнэлгээний чиглэлээр ажилладаг. Тэрээр Объектэд суурилсан дүрсийн шинжилгээ, автомат тоног төхөөрөмж ашиглаж судалгаа явуулах гэх зэрэг хамгийн сүүлийн үеийн анализ хийх аргуудыг ашигладаг олон спектрийн болон SAR алсын зайнаас тандан судлах техникийн туршлагатай. Одоогийн үүрэгт ажлаасаа өмнө Марал нь Airbus Defence and Space компанийн зайнаас тандан судлах шинжээч хийж байсан бөгөөд Судалгаа, Хөгжүүлэлт болон үйл ажиллагааны хүрээнд шинэ программ боловсруулж байв. Марал Бристолийн Их сургуульд геологийн чиглэлээр магистр (Hons) зэрэг хамгаалсан.



ЛИЗ ФИШЕР

Оксфордын Их сургуулийн Корпус Кристи коллежийн Хууль эрх зүйн тэнхимийн байгаль орчны хуулийн профессор. Тэрээр байгаль орчны эрх зүй, захиргааны эрх зүйн чиглэлээр судалгаа явуулдаг бөгөөд хуулийн өөр өөр зохицуулалт бүхий улс орны хууль эрх зүй, захиргаа, зохицуулалтын тулгамдаж буй асуудлуудын хоорондын харилцан хамаарлыг судалдаг. Ялангуяа эдгээр харилцан хамааралд шинжлэх ухааны гүйцэтгэх үүрэг чиглэлийг судалдаг. Түүний 2007 онд гаргасан "Эрсдэлийн зохицуулалт ба Захиргааны конституционализм" ном нь 2008 оны Шилдэг эрх зүйн тэтгэлэгт SLS Питер Бирксийн шагнал хүртсэн. "Байгаль орчны тухай хууль: Богино товч удиртгал" (OUP 2017), Фишер, Лэнж, Скотфорд нартай хамтран "Байгаль орчны тухай хууль: Текст, жишээ, материал" (2-р хэвлэлт, OUP 2019) бүтээл туурвисан. Тэрбээр (Journal of Environmental Law and Review Articles) "Байгаль орчны хууль, тойм өгүүлэл сэтгүүл"-ийн ерөнхий редактор бөгөөд (Oxford Journal of Legal Studies) "Оксфордын Хууль эрх зүйн судалгаа сэтгүүл"-ийн эрхлэгч. Тэрээр багшлах эрхийн шагнал хүртсэн бөгөөд 2013-2016 онд Хууль зүйн факультетийн дэд захирлын албыг хашиж байв.



КРЕЙГ МОРЛИ

Оксфордын Их сургуулийн Олон улсын стратегийн албаны стратегийн ахлах мэргэжилтэн юм. Оксфордоод ажиллаж эхлэхээс өмнө Гадаад ба Хамтын нөхөрлөлийн орнуудын газарт дипломатчаар ажиллаж байсан бөгөөд НҮБ болон Хятад, Ойрхи Дорнод, Хойд Африк зэрэг орнуудын бодлогын асуудал түүнчлэн Стратегийн харилцааны чиглэлээр алба хашиж байсан. Үүнээс өмнө парламентын гишүүний туслах, зөвлөхөөр ажиллаж байв. Тэрээр Лийдсийн их сургуулийн газарзүйн чиглэлээр бакалавр зэрэг, Лондонгийн их сургуулийн санхүү (эдийн засгийн бодлого) чиглэлээр төгсөлтийн дараах дипломын зэрэг хүртсэн.

ИЛТГЭГЧДИЙН ТОВЧ НАМТАР



КРИСТИАН РОССИ

Б.С. ба М.С. 2003, 2006 онд Италийн Миланий Полтехникний их сургуулийн холбоо харилцааны инженерийн чиглэлээр тус 2003, 2006 онуудад бакалавр, магистрийн зэрэг хүртсэн бөгөөд ХБНГУ-ын Мюнхен хотын Техникийн их сургуульд зайнаас тандан судлах чиглэлээр 2016 онд Докторын зэрэг хүртсэн. 2006-2008 онд Милан хотын Аресис компаний төслийн инженерээр ажиллаж байв. 2008-2017 онуудад тэрээр Германы Весслинг хотод байрлах Германы сансар судлалын төвд (DLR) эрдэм шинжилгээний ажилтнаар ажиллаж, TanDEM-X нийлмэл процессорыг боловсруулж, синтетик диафрагмын радар хийх шинэ интерферометрийн алгоритм боловсруулсан байна. 2017 оноос тэрээр Их Британын Дидикот хот дахь Харвелл кампуст байрлах хиймэл дагуулын аппликейшн хөгжүүлэлтийн Катапультын газрын агаараас тандан ажиглах ахлах мэргэжилтэнээр ажиллаж байна. Тэрээр газрын аппликейшнд зайнаас тандан судлах мэдээллийг ашиглах чиглэлээр үндэсний болон олон улсын хэд хэдэн төслүүдийг удирдан байна. Хотыг зайнаас тандан судлах, олон эх сурвалж бүхий мэдээллийг нийлүүлэх, DEM, байгаль орчны параметрийн тооцоо зэргийг сонирхон судалдаг.



ДОУН ЧАТТИ

Оксфордын Их сургуулийн Антропологийн Хүндэт (Emerita) профессор бөгөөд албадан дүрвэлтийн талаар судалгаа явуулдаг. Оксфордын Их сургуулийн Дүрвэгсдийн судалгааны төвийн захиралаар ажиллаж байсан. Тэрээр нийгмийн антропологич бөгөөд Ойрхи Дорнод, ялангуяа нүүдэлчид, бэлчээрийн мал аж ахуй эрхлэгч овог аймаг, дүрвэгсдийн залуу үеийн талаар этнографийн судалгаа явуулж байна. Албадлагаар дүрвэх болон хөгжлийн нөлөөллийн асуудал тухайлбал байгалийн тусгай хамгаалалттай холбогдуулан хүн амыг газар нутгаас хөөж, чөлөөлөх, овог аймгуудын нүүлгэн суурьшуулалт, орчин үеийн технологи, нийгмийн өөрчлөлт, хүйсийн асуудал, хөгжил, сунжирсан урт хугацааны зөрчлөөс дүрвэгсдийн залуу үед үзүүлэх нөлөөлөл зэрэг олон тулгамдаж буй асуудлыг судалдаг.

Доун Чатти нь антропологич бөгөөд эрдэм шинжилгээний судалгаа эрхлэх төдийгүй бодлого боловсруулах зэрэг бодит хувь нэмэр оруулах чиглэлээр ажилладаг мэргэжилтэн юм. Тэрээр АНУ, Ливан, Сири, Оман зэрэг улсын Их сургуулиудад ажиллаж байсан бөгөөд НҮБХХ, НҮБ-ын Хүүхдийн сан, FAO, IFAD зэрэг хөгжлийн агентлагуудтай хамтарч ажиллаж байв. Профессор Чатти олон бүтээл туурвиснаас хэдийг дурдвал: Тэмээнээс ачааны машин хүртэл: Өнөөгийн ертөнц дэх Бэдуэны нүүдэлчид (1986), Бэлчээрийн мал аж ахуй эрхлэгч нүүдэлчид: Оман дахь хөгжлийн төлөвлөлт ба нийгмийн өөрчлөлт (1996), Байгалийн тусгай хамгаалалт ба нүүдэлчин уугуул ард түмэн: Нүүлгэн чөлөөлөлт, суурьшуулалт тогтвортой хөгжил (2002), Нүүлгэн чөлөөлөлт ба орчин үеийн Ойрхи Дорнод дахь өмчгүйдүүлэлт (2010), Сири: Дүрвэгсдийн улсыг байгуулах ба задлах (2014).

ОКСФОРДЫН ИХ СУРГУУЛЬ



ТРОЙ СТЕРНБЕРГ

Оксфордын их сургуулийн Газарзүй, байгаль орчны сургуулийн судлаач бөгөөд говийн бэлчээр, байгаль орчны чиглэлээр голлон ажилладаг. Байгалийн гамшиг, байгаль орчны үйл явц, уламжлалт нүүдэлчдийн стратегийн үр ашиг, Азийн тал нутаг дахь экологийн амьжиргааны нөлөөллийн харьцуулсан судалгаанд төвлөрч ажиллаж байна. Тэрээр Монгол улсад явуулж буй судалгаага хөдөөгийн усан хангамж, хэрэглээг сайжруулах, ган гачиг, доройтлыг тооцоолох, Монголын бэлчээрийн мал аж ахуй, говийн байгалийг олон улсын хэмжээнд авч үзэх асуудалд түлхүү анхаардаг. Хээрийн шинжилгээний ажлаа Монгол, Хятад, Казахстан, Киргизстан, Тажикистан, Энэтхэг, Ойрхи Дорнод зэрэг улсад хийж байсан. Британийн академи, Thesiger-Oman цөлийн тэтгэлэг, Жон Фелл сан, Британийн шинжлэх ухааны шагнал, Европын Холбоо, Эзэн хааны газарзүйн нийгэмлэг, АНУ-ын Фулбрайт зэрэг шагнал, тэтгэлэгт хүртэж байв. Түүний бүтээлүүдээс хамгийн сүүлд хэвлүүлсэн нэг сэдэвт бүтээл нь 2017 оны "Азийн хүрээлэн буй орчин дахь уур амьсгалын аюул гамшиг" бүтээл юм.



ЭММА УИЛСОН

Орон нутгий иргэдийн харилцаа, уул уурхай, эрчим хүчний салбарын компанийн хариуцлагын чиглэлээр 25 жил ажилласан туршлагатай бөгөөд нийгмийн нөлөөллийн үнэлгээ, нийгмийн аудит, нийтийн ба талуудын оролцоог хангах, олон улсын стандартад дүн шинжилгээ хийх чиглэлээр ажилладаг. Тэрээр орос хэлээр чөлөөтэй ярьдаг бөгөөд Орос, Төв Ази, Норвеги, Грийнланд, Катар болон Африкийн хэд хэдэн оронд ажиллаж байв. 2007-2015 онуудад Олон улсын байгаль орчин, хөгжлийн институтид (IIED) ахлах судлаачаар ажиллаж эрчим хүчний багийг удирдаж байв. IIED-ээс гарснаас хойш хэдийгээр Их Британид төвлөрч ажилладаг боловч Төв Ази, Арктикийн эрчим хүч, олон нийтийн оролцоог хангах төслүүдэд ажиллаж байна. Эмма одоогоор Зөвлөлдөх Хүрээлэнд (Consultation Institute) ажиллаж, уур амьсгалын өөрчлөлт, байгаль орчны асуудалд олон нийтийг оролцуулах чиглэлээр зөвлөгөө, удирдамж хөтөлбөр, мэдлэг мэдээллийн материал гаргах, стратеги төлөвлөх зэрэг ажлыг голлон явуулж байна.



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН АЖЛЫН ХЭСЭГ

Говийн загвар багийн санаачилгаар Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас хамтарсан ажлын хэсгийг 2020 оны 1 сард байгуулж ажиллаж байна. Ажлын хэсгийн гол зорилго нь Монгол улсад шаардлагатай нийгмийн нөлөөллийг үнэлгээний (ННУ) аргачлал, бодлого боловсруулах явдал юм. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний (БОНБУ) тухай хуулиар Байгаль орчин аялал жуулчлалын яам байгаль орчны нөлөөллийн үнэлгээг (БОНУ) эрхлэн явуулдаг бол Эрүүл мэндийн сайдын 2012 оны тушаалын дагуу эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээг (ЭМНУ) Эрүүл мэндийн яам (ЭМЯ) хариуцдаг. Засгийн газар БОНУ, ННУ-ний аргачлалын БОНБУ-ний хуулийн 7-р заалтын дагуу боловсруулж, батлах үүрэгтэй.

"Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, үнэлгээний дүн шинжилгээ, мэргэжлийн зөвлөлийн үйл ажиллагааг хянах, зохицуулах, нийгэм, эрүүл мэндэд нөлөөлөх байдлын үнэлгээ зэрэг асуудлыг багтаасан нөлөөллийн үнэлгээний журам, аргачлалыг Засгийн газар батална."

Засгийн газар ННУ-ний аргачлал, журмыг одоогоор хараахан боловсруулж батлаагүй байна. БОНУ, ЭМНУ хийхэд ННУ-ний асуудлыг зайлшгүй авч үзэх шаардлагатай боловч хангалтгүй хийгдэж байна. Үүний уршгаар малчдад нийгмийн олон асуудал хуримтлагдан үүсэж, орон нутгийн иргэд болон дэд бүтцийн бүтээн байгуулалтын төслүүдийн хооронд үл итгэлцэл, зөрчил маргааныг ихэх болжээ. Монгол Улсын Засгийн газар ННУ-ний аргачлалыг батлах хэрэгцээ шаардлага, ач холбогдлыг бодолцож ННУ, ЭМНУ-ний аргачлалыг боловсруулахыг Ажлын хэсэгт даалгасан юм. ННУ-ний чиглэлээр туршлага, мэдлэг дутмаг байгаагаас ажлын хэсэгт хүндрэл учирах болсон байна. Ажлын хэсэгт Монголын бэлчээрийн мал аж ахуй эрхлэгч нүүдэлчдийн ахуй хэв маягт таарсан ННУ-ний үе шат болгоноор тодорхой удирдамж, аргачлал шаардагдаж байгаа юм. Ажлын хэсгийн гишүүдийг дараах хүснэгтээс харна уу!

АЛБАН ЁСНЫ АЖЛЫН ХЭСГИЙН ГИШҮҮД

АХЛАГЧ

Засгийн газрын хэрэг эрхлэх газрын Салбарын удирдлага, зохицуулалтын газар

ГИШҮҮД

- Засгийн газрын хэрэг эрхлэх газрын Салбарын удирдлага, зохицуулалтын газар
- Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Геологи уул уурхайн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар
- Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Хүрээлэн буй орчин байгалийн нөөцийн удирдлагын газар
- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хүн амын хөгжлийн газар
- Эрүүл мэндийн яамны Нийгмийн эрүүл мэндийн газар
- МХЕГ-ын Байгаль орчин, геологи, уул уурхайн хяналтын газар
- Хил хязгааргүй алхам. ТББ
- Оксфордын их сургуулийн Говийн загвар төсөл

ЗӨВЛӨХҮҮД

Оксфордын Их сургуулийн газарзүй байгаль орчны сургууль

АЖЛЫН ХЭСГИЙН ОРЛОГЧ ГИШҮҮД

Дэд ажлын хэсгийн үүрэг бол Ажлын хэсэгт туслаж аргачлал боловсруулж явдал юм. Дэд ажлын хэсэгт үнэлгээ хийж, ажиллаж байсан туршлагатай Яамдын мэргэжилтэнгүүдээс бүрдэж байна.

АХЛАГЧ

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Салбарын удирдлага, зохицуулалтын газар

ГИШҮҮД

- Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Салбарын удирдлага, зохицуулалтын газар
- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хүн амын хөгжлийн газар
- Эрүүл мэндийн яамны Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв
- Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн удирдлагын газар
- Хил хязгааргүй алхам ТББ
- Оксфордын Их сургуулийн Говийн загвар төсөл

ЗӨВЛӨХҮҮД

Оксфордын Их сургуулийн газарзүй, байгаль орчны сургууль

ГОВИЙН ЗАГВАР: 2018-2021 ОН

Хугацаа: 2018 оны 9-р сараас 2021 оны 8-р сар хүртэл
Санхүүжүүлэг: ESRC-GCRF
Хэрэгжих улс: Киргизстан, Монгол, Тажикистан
Вэбсайт: <https://gobiframework.ouce.ox.ac.uk/>



Тус төсөл Эдийн засаг, нийгмийн судалгааны зөвлөл (Их Британи) болон Дэлхийн сорилтын судалгааны сангаас (GCRF) санхүүжиж, Оксфордын Их сургуулийн Газарзүй, байгаль орчны сургууль, Киргизстан, Монгол, Тажикистаны байгууллагуудтай хамтран хэрэгжүүлж байна.

ТӨСЛИЙН ГОЛ ЗОРИЛГО:

- Дэд бүтцийг бүтээн байгуулалтын төсөлд оролцогч талуудын итгэлцэл, хамтын ажиллагаа, ил тод байдлыг бий болгоход тулгарч буй бэрхшээлийг авч үзэх; нийгэм, эдийн засгийн хувьд ач холбогдолгүй гэж орхигддог нутгийн иргэд, орон нутгийн засаг захиргааны байгууллагууд өөрсдийн амьжиргаа, байгаль орчин, газар болон байгалийн нөөцийг ашиглахад шууд нөлөө үзүүлж буй гадаадын хөрөнгө оруулалтай томоохон хэмжээний дэд бүтцийн төсөл эхлүүлэх, хэрэгжүүлэхэд түншлэн оролцох асуудлыг тусгах;
- Эвлэрүүлэн зуучлах институцын сайн тогтолцооны хүрээнд томоохон дэд бүтцийн төслүүдийн сөрөг нөлөөллийг багасгах, эдийн засгийн үр өгөөжийг ихэсгэх чиглэлээр орон нутгийн иргэд, засгийн газрын чадавхийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх
- Монголын эрдэс баялгийн салбарын туршлага сургамж, мэдлэгийг Монголоос Төв Азийн улсуудад дамжуулах, холбох.

2018 оны сүүл үеэс эхлэн Монгол Улсын хөдөөгийн 3 газарт, Киргизстаны 3 газарт хээрийн судалгаа явуулж тухай бүс нутгийн томоохон дэд бүтцийн төслүүдээс үүсэж буй зөрчил, сорилтыг судалж байна. Говийн загвар баг судалгааныхаа үр дүнгээр номын эмхтгэл, эрдэм шинжилгээний өгүүлэл, кейс судалгаа бичиж байна. Бид төсөл хэрэгжиж дууссаны дараа Төв Азийн оролцогч талууд ашиглах боломжтой вэб програмын контентыг боловсруулж байна.